

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
НИЙТИЙН НОМЫН САН**

2022.11.01

Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль								
1	1	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан батлуулж хангаж ажиллах	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн захирлын А/18 тоот тушаалаар баталсан. Хөтөлбөрийн дагуу 2022 онд жилийн төлөвлөгөө батлуулан 7 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	100		
2	2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах.	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгыг library.gs.gov.mn цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.	100		
	3		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл нийгмийн сүлжээний	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах мэдээлэл зэргийг цахим хуудсанд байршуулсан.	100		

		хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	хаягийг цахим хуудсанд байршуулах.				
4		8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 5 хууль, тогтоомж, шийдвэрүүдийг library.gs.gov.mn цахим хуудсанд иргэдэд ил тод байршуулсан.	100		
5		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан цахим хуудаст байршуулах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлангуудыг цахим хуудсанд байршуулсан.	100		
6		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 5 хууль, тогтоомж, шийдвэрүүдийг library.gs.gov.mn цахим хуудсанд иргэдэд ил тод байршуулсан.	100		
7		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг цахим хуудаст байршуулах.	Албан хаагчдын мэдээллийг цахим хуудаст байршуулсан.	100		

8	8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг хугацаанд нь гарган мэдээллийн самбар болон цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулах	Өргөдөл, гомдлын хагас жилийн болон улирлын тайлан мэдээг цахим хуудсанд байршуулсан.	100		
9	8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Аймгийн статистик мэдээллийг цахим хуудсанд байршуулах.	Байгууллагын статистик мэдээллийг иргэд уншигчдад ойлгомжтой хэлбэрээр байршуулсан.	100		
10	8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон зохион байгуулсан арга хэмжээг тогтмол байршуулах	Зохион байгуулсан арга хэмжээний мэдээ мэдээллийг цахим хуудас, фейсбүүк, пэйж хуудсанд тогтмол байршуулан ажиллаж байна.	100		
11	8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Ажлын байрны сул орон тооны судалгааг тухай бүр шинэчилж цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулах	Ажлын байрны сул орон тооны зарыг ХХҮГ-т болон цахим хуудас, пэйж хуудсаар дамжуулан мэдээллэж байна.	100		
12	8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах	Албан хаагч, ажилтныг 2 үе шаттай сонгон шалгаруулж байна.	100		
13	8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрмийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулах	Албан хаагчийн ёс дүрэм журмыг мэдээллийн самбарт болон ёс зүйн буланд байршуулан ажиллаж байна.	100		
14	8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	“Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр	“Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр төлөвлөн батлуулсан.	100		

			төлөвлөн батлуулж цахим хуудсанд байршуулах			
15		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Аймгийн цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тогтмол шинэчлэх	Хүний нөөцийн ил тод байдлын мэдээлэлд Захирлын “А тушаал 21, Б” тушаал 32-ыг тухай бүрт нь шинэчлэн байршуулж байна.	100	
16		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам болон албан хаагчдыг үнэлсэн үнэлгээг иргэдэд ил тод байдлаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	Албан хаагчдыг үнэлсэн үнэлгээг иргэдэд ил тод байдлаар мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажилладаг.	100	
17		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг нийтэд мэдээлэх	Төсвийн гүйцэтгэлүүдийг тухай бүрт нь санхүүгийн мэдээллийн ил тод байдлын самбарт байршуулж байна.	100	
18		8.4.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд байршуулсан.	100	
19		8.4.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг иргэдэд ил тодоор шилэн данс, цахим хуудсанд байршуулсан.	100	
20		8.4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж,	Төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоосон	Ном олгох журам болон Алдагдсан ном нөхөн төлүүлэх журмыг цахим хуудсанд байршуулсан.	100	

		зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	шийдвэрийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулах.			
21		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулах	Сар бүрийн 07-ны өдрийн дотор хэмнэлт хэтрэлтийн мэдээг байршуулдаг.		
22		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Фондын сан хөмрөгийг 7,000,000 сая төгрөгийн ном хэвлэл худалдан авч баяжжуулсан. Ном худалдан авсан баримтыг шилэн дансанд байршуулсан.	100	
23		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Цалингийн зардлаас бусад гүйлгээг тус бүрээр нь гүйлгээний утга агуулгатай нь шилэн дансанд нийтлэн оруулж байна.	100	
24		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч,	Аймгийн төсөв баталсан болон төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоолуудыг нийтэд мэдээлэх	Байгууллагаас гарсан тушаал шийдвэрүүдийг тухай бүрт нь шилэн данс, цахим хуудсанд байршуулсан.	100	

			хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;					
	25		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулж, нийтэд мэдээлэх	Шилэн дансанд мэдээллийг сар бүрийн 08-ны дотор бүрэн байршуулан ажиллаж байна.	100		
	26		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим хуудсанд байршуулах	Төрийн аудитын тайлан дүгнэлтийг library.gs.gov.mn хуудсанд байршуулсан.	100		
	27		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.)	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах.	Төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг тухай бүрт нь цахим хуудас, санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.	100		
Ерөнхийлөгчийн зарлиг								
3	48	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж	- Бүх шатны байгууллагын гадна, дотно хаягийг хос бичгээр бичих ажлыг зохион байгуулах - Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжих	Байгууллагаас зохион байгуулж байгаа ном уншлагын аян болон цаг үеийн мэдээллийг “Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” пэйж хуудсанд хос бичгээр бичин байршуулж байна. Монгол бичгийн самбарыг “Уран бичлэг”, “Зүйр онч үгс”, Ойролцоо утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”,	100		

		хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.		“Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр мэдээлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн. Байгууллагын гадна хаяг, албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн.			
49		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Монгол бичгийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөн зохион байгуулах	Уншигч, номыг уншиж байгаа хэсэгтээ нугалах, тэмдэглэж муухай болгохоос хамгаалах уншигчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор “НОМЫН ХАВЧУУРГА”-ыг уншигч, хүүхэд багчууд, иргэдэд зориулан 2 төрлөөр номтой холбоотой зүйр цэцэн үг уриалсан сургамжит мэдээлэл зэргийг монгол бичгээр бичиж бэлтгэн 300 ширхэгийг шинээр ирсэн номонд хийж байрлуулсан. Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит 19 дэх удаагийн “Бичиг Соёл минь-2022” монгол хэлний бүсийн олипадид Байгууллагын төрөлд хамт олоноороо оролцсон. Ном зүйч А.Чимэгмаа иргэний төрөлд оролцож “Дэд байр” эзэлсэн.	100		

					2022 оны 11 дүгээр сарын 01-04-нд Монгол бичгийн ном болон “Ховор ном судрын үзэсгэлэн” гаргасан.			
4	50	“Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 2012.08.24 №158	Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд 2022” арга хэмжээг “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” УИХ-н дарга Гомбожавын Занданшатарын ивээл дор улс орон даяар өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлэх		“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” “Илүү их уншъя”, “Номын баяр”-ын хаврын үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд 12-н төрлийн арга хэмжээг зохион байгуулж 4.496.416 мянган төгрөг зарцуулсан. 2541 иргэд, уншигчид хамрагдсан. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” “Илүү их уншъя”, “Номын баяр”-ын намрын үйл ажиллагааг 2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд 16-н төрлийн арга хэмжээг зохион байгуулж 6.003.584 мянган төгрөг зарцуулсан. 2836 уншигч, иргэд оролцсон. Хүрсэн түвшин: Үйл ажиллагааны тоо– 2 Арга хэмжээний тоо - 28 Хамрагдсан иргэдийн тоо – 5377 Зарцуулсан зардал- 10.500.000 Үүнээс: Дээд шатны байгууллагаас хуваарилсан 10.000.000 Аймгийн Соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний зардлаас 500.000	100		
5	51	Засгийн газарт чиглэл өгөх тухай	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй	Орон нутгийн төсвийн нэг хувиас доошгүй хөрөнгийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд зарцуулах	Аймгаас хувиарлаж өгсөн автозам дагуу байрлах өөрийн хуваарьт газартаа цэнэг усалгаа хийж, тогоолж			

		<p>/Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58</p>	<p>хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах</p>		<p>орчин тойрныг цэвэрлэн, шинээр 125 хайлаас мод тарьж суулгасан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж тайланг 14 хоног тутам БОАЖГ-т хүргүүлсэн.</p> <p>Иргэд уншигчдад “Мод хэрхэн тарих талаар” мэдлэг олгохоор “ЯАГААД” нэртэй танин мэдэхүйн цувралд орсон” Ургамлын амьдрал” “Байгалын хөтөч” “Хатагтай танд тасалгааны ургамал” зэрэг танин мэдэхүйн ургамлын номнуудаар цуврал контентуудыг бэлтгэн Говвсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан пэйж хуудсаар байршуулан сурталчилсан. Нийт 1100 уншигч иргэд үзэж хамрагдсан байна.</p> <p>Үр дүн: Ногоон байгууламжийн хамрах талбай авто замын дагуу баруун талын 2014/11 ойн зурвас газар 2014 оноос хойш тарьсан модны нийт тоо 383.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ургасан модны тоо 258. 2. Шинээр тарьсан модны тоо 125 мод тарисан. 	100		
6	54		<p>2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи,</p>	<p>Сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах.</p>	<p>Албан хаагчид, ажилчдыг архи, согтууруулах ундааг ажлын байранд хэрэглэхгүй байхыг байгууллагын</p>	100		

		согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдэд өндөр болон сул агууламжтай архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглох. Ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байх.	дотоод журмын 6.2.6-д оруулж албан хаагчдад танилцуулж анхааруулсан..			
--	--	---	---	---	--	--	--

ЗГ-ЫН ТОГТООЛ

7	55	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	Иргэдэд угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлын талаарх сургалт, мэдээлэл хүргэх, угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоог нэмэгдүүлэх	Байгууллагын хэмжээнд албан хаагч бүр "Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар"-ыг баримтлан өөрийн ураг төрлийн хүрээгээ тогтоож уг бичгийн дэвтэрийг хөтлөж хэвшсэн. Угийн бичгийн зураглалыг эцэг эхийн хоёрынхоо ураг төрлийн талуудаар хийсэн. "Угийн бичиг хөтлөх аргачлал", "Угийн бичиг хөтлөх арга зүй" сургалтад албан хаагчдыг хамруулж, Угийн бичиг хөтлөлтийн талаарх зөвлөлдөх уулзалт 2022 хамт олоноороо оролцсон. Үр дүн: Угийн бичгийн сургагч багшаар номын санч, мэдээллийн ажилтан Б.Аасүрэнг бэлтгэж, угийн бичиг хөтлөх ажил хэвшсэн.	100		
---	----	--	--	---	--	-----	--	--

8	56	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 2020-01-08 Дугаар 2020_9			05-06 дугаар саруудад улсын үзлэг, тооллого хийгдсэн.			
9	57	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай 2021-04-08 Дугаар 2021_93	5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Төсвийн зохицуулалтыг шуурхай хийх, цаашид өр, авлага үүсгэхгүй ажиллах	Үүсгэсэн өр авлагабайхгүй. Өр авлага үүсгэхгүй ажиллаж байна.	100		
10	58	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан	Төрийн албан хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулах	Үндэсний номын сангаас зохион байгуулсан Тогтмол хэвлэлийн улсын нэгдсэн санд орон нутгийн гаргасан тогтмол хэвлэлийг бүртгэж оруулах сургалтад 2 албан хаагч хамрагдсан. Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс “Харилцаа хандлага ёс зүйн сэдвээр сургалт захиалан авсан.	100		

		<p>Дугаар 2022_203</p>	<p>“Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>		<p>Хууль эрх зүйн хэлтсээс Авлигын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн тухай хууль</p> <p>Боржигин Өв Музейгээс Угийн бичгийн сургалт зэрэг байгууллагаас болон бусад мэдлэг, чадвар, чадамж нэмэгдүүлэх богино хугацааны сургалтанд албан хаагчдыг хамруулан ажилласан.</p> <p>Говьсүмбэр номын сан монгол бичгийн хичээл групп чат нээж Л.Лоохууз багшаар монгол бичгийн дүрмийн хичээлүүдийг заалган өдөр бүр сургалт авч байна. 3,4,5-н сард нийт 15 удаа сургалт авсан.</p> <p>Соёлын яам, СУИС-ийн Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан Лавлагаа ном зүйн кредит олгох, Дижитал маркетингийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад албан хаагчдыг хамруулж чадавхжуулсан. 5 албан хаагч 6 өдрийн 30-н төрлийн хичээлийн онлайн сургалтад хамрагдаж шалгалт өгч сертификат авсан.</p> <p>2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ERP.E-Mongolia.mn цахим сургалтад 7 албан хаагч хамрагдсан. “NEW STORY” хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёлын яамтай хамтарсан сургалтад 2 албан</p>			
--	--	----------------------------	---	--	---	--	--	--

				<p>хаагч хамрагдаж Говьсүмбэр аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ХНУМТ системийн сургалтад 2 албан хаагч, Корнавирист халдвар /ковид-19/-ийн тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам, Манлайллын хэв маяг, хандлага тодорхойлох нь, Алдаа дутагдлыг шийвдэрлэх нь зэрэг сургалтуудад 7 албан хаагч хамрагдсан.</p> <p>Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалнуудад зориулсан авлигын эсрэг анхан болон дунд шатны сургалтад 7 албан хаагч, Таны эрх таны оролцоо авлигалд үгүй гэж хэлье иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх сургалтад 10 албан хаагч тус тус хамрагдсан.</p> <p>Онцгой байдлын газраас “Галын аюулгүй байдал”, “Хувь хүний хөгжил ба хандлага, сэтгэлгээний өөрчлөлт”, “Амар амгалан Говьсүмбэрийн төлөө”,</p> <p>Аюулгүй байдал хамгаалалтын академ”-ийн хамгаалалтын ажилтан</p>			
--	--	--	--	---	--	--	--

					<p>бэлтгэх “Очир” сургалтын төвд 210 цагийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж сертификат авсан.</p> <p>Хил хязгааргүй номын сан төслийн Номын санчдыг чадавхижуулах сургалт 11 дүгээр сарын 21-нд</p>			
11	63	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7</p>	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3.</p>	<p>Байгууллагуудын гадна болон дотор хаягжилтийг 85 хувьд хүргэх, төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ</p>	<p>Нийт албан хаагчдад Монгол бичгээр бичиж, унших дадлага сургалтыг өдөр бүр хийж хэвшсэн.</p> <p>Л.Лоохууз багшаар монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг 3 удаа танхимаар авсан.</p> <p>Говьсүмбэр номын сан монгол бичгийн хичээлийн групп чат нээж өдөр бүр Л.Лоохууз багшаар хичээл заалган даалгавар авч даалгаварыг “Чойр номын сан” группд байршуулан Ном зүйч А.Чимэгмаа шалгаж хэвшсэн.</p> <p>Албан хаагчид монгол бичгээ сурахад Э.Олонцэцэг багшийн гаргасан Үндэсний бичгээ шамдан сурцгаая-1 номыг ашиглаж байна.</p> <p>14 хоног тутамд Монгол хэлний бодлогын салбар зөвлөл, Соёл, урлагийн газарт монгол бичгийн тайланг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Монгол бичгийн ахисан шатанд А.Чимэгмаа, Б.Аасүрэн, нар компьютер болон чимээ апп-р ертөнцийн гурав, эрдэнийн сан,</p>	100		

		<p>төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>		<p>субашидаас өдөр бүр бичин суралцаж байна.</p> <p>Байгууллагаас зохион байгуулж байгаа ном уншлагын аян болон цаг үеийн мэдээллийг “Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” пэйж хуудсанд хос бичгээр бичин байршуулж байна.</p> <p>Монгол бичгийн самбарыг “Уран бичлэг”, “Зүйр онч үгс”, Ойролцоо утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”, “Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр мэдээлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн.</p> <p>Албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн.</p> <p>Уншигч, номыг уншиж байгаа хэсэгтээ нугалах, тэмдэглэж муухай болгохоос хамгаалах уншигчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор “НОМЫН ХАВЧУУРГА”-ыг уншигч, хүүхэд багчууд, иргэдэд зориулан 2 төрлөөр номтой холбоотой зүйр цэцэн үг уриалсан сургамжит мэдээлэл зэргийг монгол бичгээр бичиж бэлтгэн 300 ширхэгийг шинээр ирсэн номонд хийж байрлуулсан.</p> <p>“Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” цахим хуудсуудаар дамжуулан өглөөний мэндчилгээ, онч мэргэн</p>			
--	--	--	--	--	--	--	--

					үгсийг хос бичгээр байршуулж иргэдэд хүргэж байна.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл								
12	66	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэх И-Монголиа системд орон нутгаас үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг холбох	2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр админ эрх авч байгууллагын 10 албан хаагчдыг бүртгэн ERP системийг нэвтрүүлэн ажиллаж байна. ERP системийн 10 цэсийг бүрэн ашиглаж, албан хаагчдад үүрэг даалгавар өгч, албан бичиг шилжүүлэх, ирсэн явсан бичгийг тогтмол хүлээн авч, ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ERP системээр явууж байна.	100		
13	67	2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23	X.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд	1. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг олон сувгаар хүлээн авах 2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл,	Бичгээр 20 өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Бичгээр хүлээн авсан өргөдөл гомдлоо цахимжуулж ERP системд бүртгэсэн. Цахимаар өргөдөл гомдол, санал хүсэлт ирээгүй болно.	100		

		<p>Дугаар 2022_12</p>	<p>олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн</p>	<p>гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын тайланг нэгтгэн Засгийн газрын хэрэг Эрхлэх газарт хүргүүлэх.</p>				
--	--	---------------------------	--	---	--	--	--	--

			Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.					
14	68	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	<p>XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг</p>	Тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах, сурталчлах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулж, үр дүнг нэгтгэн тайлагнах	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын дарга, нягтлан бодогч нар 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тоон гарын үсэг авсан. 2022 оны 07-08 дугаар саруудад 10 албан хаагч тоон гарын үсэг авч эзэмшсэн.	100		

			дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.					
ЗГ-ын албан даалгавар								
15	69	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх хэмжээ авах;	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах.	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын дарга, нягтлан бодогч нар 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тоон гарын үсэг авсан. 2022 оны 07-08 дугаар саруудад 10 албан хаагч тоон гарын үсэг авч эзэмшсэн.	100		

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

САН ХӨМРӨГЧ, ХҮНИЙ НӨӨЦ

М.АЮУШЖАВ

ХЯНАСАН:

ЗАХИРАЛЫГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРНАЙ